

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тариалан сумын эрүүл мэндийн төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/064/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2025 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn Аудитор: Г.Ичинхорлоо Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com Аудитор Ц.Мөнхтуяа Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2025.08.25 № 1/164

танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тариалан сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тариалан сумын эрүүл мэндийн төв нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,719,046.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 1,359,155.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 359,890.9 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 9,672.0 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс, 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага, 6 зөвлөмж өгч, 3 алдааг залруулсан.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Тариалан сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 80.5 хувьтай дүгнэсэн байна.

6/25/2025

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	274,637,615.99	544,170,032.47
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	118,659,824.77	22,474,043.99
312	Банканд байгаа бэлэн мөнгө	118,659,824.77	22,474,043.99
3121	Төгрөг	118,659,824.77	22,474,043.99
31211	Төрийн сангийн харилцах	118,659,824.77	22,474,043.99
33	АВЛАГА	30,037,313.00	360,347,779.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	456,888.30
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	30,037,313.00	359,890,891.52
35	БАРАА МАТЕРИАЛ	125,940,478.22	161,348,208.66
351	Түүхий эд материал	33,590,211.01	65,587,855.45
35130	Эм боох материал	33,590,211.01	65,587,855.45
354	Хангамжийн материал	91,559,740.21	94,969,826.21
35410	Бичиг хэргийн материал	2,156,310.00	4,052,710.00
35420	Аж ахуйн материал	33,071,302.46	33,071,302.46
35440	Түлш, шатах тослох материал	2,000,000.00	2,000,000.00
35460	Хүнсний материал	762,966.00	26,561.00
35470	Бусад хангамжийн материал	53,569,161.75	55,819,252.75
35600	Мал амьтад	790,527.00	790,527.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	672,078,543.87	954,615,552.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	672,078,543.87	954,615,552.42
392	Биет хөрөнгө	648,836,343.95	931,382,519.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	533,369,047.61	533,369,047.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(130,417,189.76)	(132,751,548.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,575,692.00	245,475,058.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	(33,534,080.85)	(47,326,736.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	323,177,299.31	491,930,621.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	(128,567,108.03)	(173,732,241.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,326,959.00	53,985,959.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,094,275.33)	(39,567,640.62)
393	Биет бус хөрөнгө	23,242,199.92	23,233,033.25
39301	Программ хангамж	725,000.00	725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(395,000.08)	(404,166.75)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,912,200.00	22,912,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	946,716,159.86	1,498,785,584.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	68,259,737.38
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	68,259,737.38
413	Өглөг	0.00	68,259,737.38
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	1,578,435.38
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	47,742,902.00
4136	Бусад өглөг	0.00	18,938,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	17,288,400.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	1,650,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	946,716,159.86	1,430,525,847.51
51	Засгийн газрын хувь оролцоо	946,716,159.86	1,430,525,847.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	332,460,354.00	332,460,354.00
51101	Өмч: - төрийн	332,460,354.00	332,460,354.00
512	Хуримтлагдсан үр дүн	190,836,879.01	674,646,566.66
51210	Өмнөх үеийн үр дүн	190,836,879.01	190,836,879.01
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	483,809,687.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	423,418,926.85	423,418,926.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	946,716,159.86	1,498,785,584.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,287,953,688.56	2,143,143,463.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,553,857.51	406,981,293.46
120	Нийтлэг татварын бус орлого	63,553,857.51	406,981,293.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	63,553,857.51	406,981,293.46
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	63,553,857.51	327,679,293.46
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	79,302,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,224,399,831.05	1,736,162,170.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,288,400.00	47,153,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	44,288,400.00	47,153,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,180,111,431.05	1,689,008,870.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,180,111,431.05	1,689,008,870.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,291,796,309.27	1,659,333,776.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,291,796,309.27	1,577,127,776.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,291,796,309.27	1,577,127,776.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	788,391,393.78	1,035,075,440.00
210101	Үндсэн цалин	506,114,043.56	585,265,749.35
210102	Нэмэгдэл	212,971,572.35	333,543,775.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,240,000.00	22,186,000.00
210104	Урамшуулал	63,065,777.87	94,079,915.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,743,674.20	132,720,585.64
210201	Тэтгэврийн даатгал	67,559,631.90	87,720,808.42
210202	Тэтгэмжийн даатгал	7,948,192.67	10,116,774.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,330,128.01	9,629,272.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,507,009.67	5,269,897.09
210205	Эрүүл мэндийн даатгал	15,398,711.95	19,983,832.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,897,400.00	43,883,300.00
210301	Гэрэл, цахилгаан	4,128,800.00	5,774,600.00
210302	Түлш, халаалт	36,108,600.00	36,108,700.00
210303	Цэвэр, бохир ус	2,660,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,098,900.02	75,446,709.50
210401	Бичиг хэрэг	1,784,200.00	2,035,500.00
210402	Тээвэр, шатахуун	40,442,650.00	47,938,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,971,660.02	3,432,445.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,859,800.00	319,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,040,590.00	21,721,264.00
2105	Нормативт зардал	186,463,889.21	192,460,173.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	156,978,724.21	159,808,341.25
210502	Хоол, хүнс	29,485,165.00	32,651,832.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,816,300.00	18,185,100.00
210604	Урсгал засвар	5,816,300.00	18,185,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,596,000.00	5,328,000.00
210702	Дотоод албан томилолт	2,596,000.00	5,328,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,330,240.00	3,041,968.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,529,190.00	2,301,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	240,000.00	129,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,800.00	49,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	115,600.00	12,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	898,000.00	478,000.00

210807	Газрын төлбөр	85,400.00	71,568.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,184,250.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,458,512.06	70,986,499.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,486,400.00	4,211,820.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	89,972,112.06	66,774,679.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	82,206,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	82,206,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	82,206,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(3,842,620.71)	483,809,687.65
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,358,458.85	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	8,358,458.85	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(8,358,458.85)	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(12,201,079.56)	483,809,687.65

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>1,194,362,518.05</u>	<u>1,485,840,591.98</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	79,302,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	79,302,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	79,302,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	79,302,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,194,362,518.05	1,406,538,591.98
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,288,400.00	47,383,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	44,288,400.00	47,383,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,150,074,118.05	1,359,155,291.98
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,150,074,118.05	1,359,155,291.98
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,176,297,396.00</u>	<u>1,532,867,372.76</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,176,297,396.00	1,532,867,372.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,176,297,396.00	1,450,431,372.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	788,391,393.78	1,033,833,892.92
210101	Үндсэн цалин	506,114,043.56	584,015,720.77
210102	Нэмэгдэл	212,971,572.35	333,552,256.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,240,000.00	22,186,000.00
210104	Урамшуулал	63,065,777.87	94,079,915.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,743,674.20	132,720,585.64
210201	Тэтгэврийн даатгал	67,559,631.90	87,720,808.42
210202	Тэтгэмжийн даатгал	7,948,192.67	10,116,774.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,330,128.01	9,629,272.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,507,009.67	5,269,897.09
210205	Эрүүл мэндийн даатгал	15,398,711.95	19,983,832.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,897,400.00	43,883,300.00
210301	Гэрэл, цахилгаан	4,128,800.00	5,774,600.00
210302	Түлш, халаалт	36,108,600.00	36,108,700.00
210303	Цэвэр, бохир ус	2,660,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60,254,250.02	66,436,350.50
210401	Бичиг хэрэг	1,560,000.00	3,156,800.00
210402	Тээвэр, шатахуун	39,874,600.00	43,328,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,971,660.02	3,212,445.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,398,350.00	4,229,200.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,449,640.00	12,509,755.00
2105	Нормативт зардал	149,376,792.00	139,142,335.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	124,426,082.00	118,294,835.70
210502	Хоол, хүнс	24,950,710.00	20,847,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,855,300.00	17,065,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,471,400.00	0.00
210604	Урсгал засвар	4,383,900.00	17,065,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,596,000.00	3,798,000.00
210702	Дотоод албан томилолт	2,596,000.00	3,798,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,216,186.00	3,041,968.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,599,386.00	2,301,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	240,000.00	129,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,800.00	49,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	115,600.00	12,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	898,000.00	478,000.00
210807	Газрын төлбөр	85,400.00	71,568.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,966,400.00	10,509,840.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,966,400.00	10,509,840.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	82,436,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	82,206,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	82,206,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	230,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	230,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18,065,122.05	(47,026,780.78)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,985,600.00	49,159,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,985,600.00	49,159,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,985,600.00	49,159,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,985,600.00	49,159,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(16,985,600.00)	(49,159,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,079,522.05	(96,185,780.78)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	117,580,302.72	118,659,824.77
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	118,659,824.77	22,474,043.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	332,460,354.00	430,241,795.15	203,037,958.57	965,740,107.72
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-12,201,079.56	-12,201,079.56
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,460,354.00	423,418,926.85	190,836,879.01	946,716,159.86

2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	332,460,354.00	423,418,926.85	190,836,879.01	946,716,159.86
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	332,460,354.00	423,418,926.85	190,836,879.01	946,716,159.86
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	483,809,687.65	483,809,687.65
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,460,354.00	423,418,926.85	674,646,566.66	1,430,525,847.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,690,690,000.00	1,534,643,072.76	90.77	156,046,927.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,690,690,000.00	1,534,643,072.76	90.77	156,046,927.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,608,484,000.00	1,452,437,072.76	90.30	156,046,927.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,106,028,100.00	1,033,833,892.92	93.47	72,194,207.08
210101	Үндсэн цалин	664,335,000.00	584,015,720.77	87.91	80,319,279.23
210102	Нэмэгдэл	344,163,100.00	333,552,256.90	96.92	10,610,843.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,880,000.00	22,186,000.00	186.75	(10,306,000.00)
210104	Урамшуулал	85,650,000.00	94,079,915.25	109.84	(8,429,915.25)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,437,900.00	132,720,585.64	93.84	8,717,314.36
210201	Тэтгэврийн даатгал	92,915,100.00	87,720,808.42	94.41	5,194,291.58
210202	Тэтгэмжийн даатгал	10,931,200.00	10,116,774.70	92.55	814,425.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,864,600.00	9,629,272.96	97.61	235,327.04
210204	Ажилгүйдлийн даатгал	5,864,600.00	5,269,897.09	89.86	594,702.91
210205	Эрүүл мэндийн даатгал	21,862,400.00	19,983,832.47	91.41	1,878,567.53
2104	Хангамж, бараа материалын зардал	89,644,200.00	65,199,850.50	72.73	24,444,349.50
210401	Бичиг хэрэг	9,300,000.00	3,156,800.00	33.94	6,143,200.00
210402	Тээвэр, шатахуун	51,817,100.00	42,091,650.00	81.23	9,725,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,016,100.00	3,212,445.50	106.51	(196,345.50)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,720,900.00	4,229,200.00	43.51	5,491,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,790,100.00	12,509,755.00	79.23	3,280,345.00
2105	Нормативт зардал	166,125,700.00	140,378,835.70	84.50	25,746,864.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	139,278,200.00	119,531,335.70	85.82	19,746,864.30
210502	Хоол, хүнс	26,847,500.00	20,847,500.00	77.65	6,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	79,115,400.00	62,954,100.00	79.57	16,161,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	63,199,000.00	49,159,000.00	77.78	14,040,000.00
210604	Урсгал засвар	15,916,400.00	13,795,100.00	86.67	2,121,300.00
2107	Томилголт, зочны зардал	4,500,000.00	3,798,000.00	84.40	702,000.00
210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	3,798,000.00	84.40	702,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,657,600.00	3,041,968.00	45.69	3,615,632.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,629,000.00	2,301,100.00	87.53	327,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	0.00	0.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	240,000.00	129,000.00	53.75	111,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,800.00	49,500.00	39.35	76,300.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	102,600.00	12,800.00	12.48	89,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	775,600.00	478,000.00	61.63	297,600.00
210807	Газрын төлбөр	85,400.00	71,568.00	83.80	13,832.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	699,200.00	0.00	0.00	699,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,975,100.00	10,509,840.00	70.18	4,465,260.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,975,100.00	10,509,840.00	70.18	4,465,260.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,206,000.00	82,206,000.00	100.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	82,206,000.00	82,206,000.00	100.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	82,206,000.00	82,206,000.00	100.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,690,690,000.00	1,438,457,291.98	85.08	252,232,708.02
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,473,964,400.00	1,359,155,291.98	92.21	114,809,108.02
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,473,964,400.00	1,359,155,291.98	92.21	114,809,108.02
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	216,725,600.00	79,302,000.00	36.59	137,423,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	97,865,900.00	79,302,000.00	81.03	18,563,900.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	118,859,700.00	0.00	0.00	118,859,700.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	118,659,824.77		(118,659,824.77)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	22,474,043.99		(22,474,043.99)

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	/ төгрөгөөр / Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,383,300.00	47,153,300.00	99.51	230,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,383,300.00	47,153,300.00	99.51	230,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,383,300.00	47,153,300.00	99.51	230,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,883,300.00	43,883,300.00	100.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	5,774,600.00	4,394,100.69	76.09	1,380,499.31
210302	Түлш, халаалт	36,108,700.00	37,489,199.31	103.82	-1,380,499.31
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00	100.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,500,000.00	3,270,000.00	93.43	230,000.00
210604	Урсгал засвар	3,500,000.00	3,270,000.00	93.43	230,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,383,300.00	47,153,300.00	99.51	230,000.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,383,300.00	47,153,300.00	99.51	230,000.00
320001	Орон нутгийн төсвөөс	47,383,300.00	47,153,300.00	99.51	230,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,672.0 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс, 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага, 6 зөвлөмж өгч, 3 алдааг залруулсан.

3.1 Залруулсан алдаа

- Төсвийн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг гаргаж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3 заалтад заасан “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл,” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн болон зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байсныг аудитын явцад нөхөж бэлтгэсэн.
- Эдийн засгийн ангилал зөрчиж, гэрэл цахилгааны зардлаас 1,380.5 мянган төгрөгийн халаалтын зардал төлсөн, тээвэр шатахууны зардлаас 1,236.5 мянган төгрөгийн эмийн зардал төлсөн Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй алдааг аудитын явцад залруулсан.
- Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 456.9 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал олгосон Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан "төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7. "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй." заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй алдаа, зөрчлийг аудитын явцад Тариалан сумын эрүүл мэндийн төвийн төрийн сан банкны 100170020010 тоот дансанд тушааж байгууллагыг хохиролгүй болгож залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 6,598.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 20,675.9 мянган төгрөгөөс 14,077.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.2 Төлбөрийн акт

Тариалан сумын эрүүл мэндийн газрын дарга Д.Дуламсүрэн эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 1,203.0 мянган төгрөгийн урамшуулал авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 заалтыг зөрчиж, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул төлбөрийн акт тогтоолоо.

3.3 Албан шаардлага

- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20,000.0 мянган төгрөгөөс 77,612.9 мянган төгрөгөөр давсан дүнгээр эмийн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил,

үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.” заалттай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

- Бараа материалын үлдэгдэлд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 2,521.3 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бараа, ажил үйлчилгээний бусад зардлыг оруулалгүй орхигдуулсан, тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 48 дугаар зүйлийн 48.2.1 “Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;” Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.11 “Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна.” гэж заасантай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлант оны төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг төлөвлөх, өөрчлөлт орсон тухай бүрд нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулах.

3. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал

Илрүүлэлт:

2024 онд 1,802,188.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 113,179.6 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 3.1 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж...” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

4. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэсэн ганц шалгуураар 2,873.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1 заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;” мөнгөн урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

5. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 36, зарлагын 10 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 16 шийдвэр, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, байгууллагын батлагсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө,

ЭМТ-ийн дарга, нягтлан бодогч нарт урамшуулал олгохдоо аудитын тайланд тусгагдсан алдаа, зөрчил болон санхүүгийн тайлангийн хугацаа, чанар, өр, авлага зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзалгүй олгосон.	1	2,873.8					1	2,873.8
Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр урамшуулал авсан	1	1,203.0	1	1,203.0				
Дүн	3	4,076.8	1	1,203.0			2	2,873.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Эм, эмнэлгийн хэрэгслэлийн шууд худалдан авалтын дүн шууд худалдан авах дээд хязгаараас давсан.	1	-			1	-		
Тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг тусгаж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй, зарим зардлыг ХАА-ны төлөвлөгөөнд тусгаагүй.	1	-					1	-
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэн зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1	-					1	-
Бараа материалын үлдэгдэлд жилийн турш хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн эмийн үлдэгдэлтэй байна.	1	2,521.3			1	2,521.3		
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй	1	-					1	-
Дүн	6	2,521.3			2	2,521.3	4	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 47/НЭЭТӨ 469/

Мөрөн сум

ХӨА-2025/064/НА-ОА МС

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын үлдэгдлийг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар зарлагдаагүй, эмчилгээнд хэрэглэх шаардлага гараагүй, эмийн үлдэгдэлд тавих дотоод хяналт сул зэрэг шалтгаанаар тус байгууллагын бараа материалын дансны үлдэгдэлд 2,521,337 (хоёр сая таван зуун хорин нэгэн мянга гурван зуун гучин долоо) төгрөгийн өмнөх оноос шилжиж ирсэн, бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй эм бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материалыг үр ашиггүй удаан хадгалахгүй байх, эмийн үлдэгдэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, бараа материалын үлдэгдлийн эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг тууштай мөрдөж ажиллах, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Дуламсүрэн, нягтлан бодогч Д.Хишигбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

6724070491



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 48/19270469/

Мөрөн сум

ХӨА-2025/064/НА-СТА-1113

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эмийн шууд худалдан авалтын дүн нь "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох барааны төсөвт өртгийн дээд хязгаараас 77,612,900 (далан долоон сая зургаан зуун арван хоёр мянга есөн зуун) төгрөгөөр хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Дуламсүрэн, нягтлан бодогч Д.Хишигбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЗБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

6724030488



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 65/А2270469/

Мөрөн сум

ХАА - 2025/064/НА - УТА - 7443

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Дуламсүрэн 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/02 тушаалаар өөртөө 20 хувийн цалингийн нэмэгдлийг 3 сарын хугацаатай олгох шийдвэр гаргаж, 1,203,000 (нэг сая хоёр зуун гурван мянга) төгрөгийн нэмэгдэл цалин авсан байна.

Дээрх зөрчил нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно." заалттай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3. "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Үндэслэлгүйгээр илүү олгосон цалин хөлс 1,203,000 (нэг сая хоёр зуун гурван мянга) төгрөгийг тус Эрүүл мэндийн төвийн дарга Д.Дуламсүрэнгээс суутган тооцож, Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор нотлох баримтын хамт оруулж, баталгаажуулахыг Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Дуламсүрэн, нягтлан бодогч Д.Хишигбат нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

6724020616